Хор уршигтай бурангуй ёс

Өдөр бүр, дэлхий даяар хэдэн зуун мянган **GIRLS around the world ARE HARMED PHYSICALLY OR PSYCHOLOGICALLY,** эцэг эх, найз нөхөд, олон нийт мэдэхийн дээдээр мэдэж, зарим нь бүр охидыг ингэж хохироохыг зөвшөөрч байна. Үүний улмаас нийгэм даяар жендэрийн хэвшмэл буруу ойлголт, тэгш бус байдал улам газар авч байна.

Асар олон төрлийн бурангуй ёс уламжлал байдгаас эм бэлэг эрхтэнг эрэмдэглэх, хүүхдийн гэрлэлт болон эрэгтэй хүүхдийг илүү чухалчилдаг уламжлалыг дэлхий дахин бараг бүх нийтээрээ хүний эрхийн зөрчилд тооцож, эсэргүүцэж байгаа ч амь бөхтэй, тархсаар байна.

Энэ уламжлалууд хил, соёл дамнан оршдог бөгөөд хэрэгжүүлэх аргууд нь янз бүр байдаг. Тухайлбал, зарим оронд охин хүүхдийг нярай байхад эсвэл өсвөр насанд бэлгийн уруулыг нь огтолж, бэлгийн хүчирхийллээс “хамгаалах” нэрийдлээр эсвэл арилжааны хэрэгсэл болгон хүчээр гэрлүүлж, зарим оронд охин хүүхдийг хорвоод мэндлэхээс нь өмнө үр хөндүүлж авахуулах юмуу эсвэл төрснийх нь дараа үл хайхран, үхэлд хүргэж байна. Эдгээр уламжлал бүгд жендэрийн тэгш бус байдал, эмэгтэйчүүдийн бэлгийн амьдрал, нөхөн үржихүйг хянах хүслээс үүдэлтэй. Үүний улмаас охид, эмэгтэйчүүд хувь хүнийхээ хувьд асар их хохирч, энэ нь дэлхий ертөнцөд маш их хохирол учруулж, хойч үед учрах хохиролыг нэмэгдүүлж байна. Охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, хөгжил доройтсоноор нийт хүн төрөлхтний хөгжил ч удааширч байна.

Гэвч энэхүү хор уршигтай бурангуй ёсыг халж, охид бүр, эмэгтэй хүн бүр ирээдүйгээ цогцлоох эрх чөлөөтэй ертөнцийг бүтээх хүч чадал бидэнд бий.

КОВИД-19 ЦАР ТАХАЛ ЭРСДЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙНА

2020 оны дэлхийн хүн амын байдлын тайланг КОВИД-19 цар тахлын эхэн үед боловсруулав.

Тайланг танилцуулж буй энэ өдрийг хүртэл дэлхий даяар цар тахал хортой бурангуй уламжлалд хэрхэн нөлөөлсөн тухай мэдээлэл бага байна. Гэвч: Нэгдүгээрт, хүүхдийн гэрлэлт, эм бэлэг эрхтэнг эрэмдэглэх (ЭБЭЭ) явдлыг таслан зогсоох хөтөлбөрүүдийн хэрэгжилт ихээхэн удааширч; Хоёрдугаарт, цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямралын улмаас охид хор уршигтай уламжлал бүхий сөрөг зүйлд өртөх эрсдэл ихсэж байгаа нь илт байна.

Эм бэлэг эрхтэнг эрэмдэглэх явдал, хүүхдийн гэрлэлт зарим бүс нутагт өсч байна гэсэн мэдээг НҮБ-ын Хүн амын сан хүлээж аваад байна. Энэ нь түр зуурын шинжтэй байж болох ч, цар тахлын улмаас хор уршигтай энэ хоёр уламжлалын аль алиных нь үр дагавар ихсэж болзошгүй хэмээн тооцоолсон НҮБ-ын Хүн амын сан Авенир эрүүл мэндийн байгууллага, Жонс Хопкинсийн их сургууль (АНУ), Викториагийн их сургууль хамтран (Австрали) 2020 оны 4-р сард хийсэн дүн шинжилгээтэй тохирч байна.

Эм бэлэг эрхтэнг эрэмдэглэх явдлаас урьдчилан сэргийлэх хөтөлбөр цар тахлын улмаас хоёр жил саатвал, сэргийлж болох байсан ЭБЭЭ-ийн 2 сая тохиолдол ирэх арван жилд гарч болзошгүй гэж эрдэмтэд тооцоолж байна.

Мөн хүүхдийн гэрлэлтийг таслан зогсоох хөтөлбөрүүд цар тахлын улмаас нэг жил саатвал, сэргийлж болох байсан хүүхдийн гэрлэлт ирэх арван жилд 7.4 саяар өсч, цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямралын улмаас 2020-2030 онд 5.6 сая хүүхэд гэрлэхэд хүрч болзошгүй байна. Урьдчилан тооцоолсоноор КОВИД-19 цар тахлын улмаас хүүхдийн гэрлэлт нийтдээ 13 саяар нэмэгдэж болзошгүй байна.

UNFPA

БҮХ ХҮНИЙ ЭРХ, СОНГОЛТЫГ БАТАЛГААЖУУЛЪЯ

#AGAINSTMYWILL | WWW.UNFPA.ORG/SWOP
#МИНИЙХҮСЭЛЗОРИГИЙНЭСРЭГ | WWW.UNFPA.ORG/SWOP

ТОЙМ

ХҮСЭЛ ЗОРИГИЙН МИНЬ ЭСРЭГ

ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ХОР ХӨНӨӨЛ УЧРУУЛЖ, ТЭГШ БАЙДЛЫГ АЛДАГДУУЛДАГ БУРАНГУЙ ЁСЫГ ХАЛЦГААЯ

UNFPA 2020 ОНЫ ДЭЛХИЙН ХҮН АМЫН БАЙДАЛ



Тэр бол арилжиж болдог хөрөнгө.

Тэр бол хүсэл хангах хэрэгсэл.

Тэр бол хаях ёстой ачаа.

Тэр бол үнэгүй ажилчин.

Тэр бол **ОХИН** хүүхэд

Энэ бол хар бараан ертөнцийн бодит байдал:

Тэд бие махбод, амьдрал, ирээдүйнхээ эзэн нь байж чаддаггүй.

ГЭХДЭЭ ҮҮНИЙГ ӨӨРЧИЛЖ БОЛНО.

ЭМ БЭЛЭГ ЭРХТЭНГ ЭРЭМДЭГЛЭХ:

Огтлох, тайрах, оёх

Эм бэлэг эрхтэнг эрэмдэглэх (ЭБЭЭ) гэдэг нь эмчилгээний бус зорилгоор эмэгтэйчүүдийн гадна бэлэг эрхтнийг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь авч хаях эсвэл эрэмдэглэхийг хэлнэ.

ЭНЭ УЛАМЖЛАЛ ДЭЛХИЙН БҮХ БҮС НУТАГТ БАЙДАГ БӨГӨӨД ӨДГӨӨ АМЬД БАЙГАА 200 САЯ ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮД ҮҮНД ӨРТӨӨД БАЙНА.

Энэ уламжлал охид, эмэгтэйчүүдийн эрүүл амьдрах, бие махбодын хувьд бүрэн бүтэн байх, ялгаварлан гадуурхалт, хэрцгий гутаан доромжлолтоос ангид байх эрхийг ноцтой зөрчиж, зарим тохиолдолд охид, эмэгтэйчүүдийн амь насанд хүрч байна.

Гэвч энэ уламжлал эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн чадавхыг сайжруулж, эрчүүдийн бэлгийн таашаалыг нэмэгдүүлж, эмэгтэйчүүдийн бэлгийн дур хүслийг бууруулж, олон нийтээр хүлээн зөвшөөрсөн шашны шаардлагад нийцдэг гэсэн ташаа итгэл үнэмшлийн улмаас одоо ч амь бөхтэй оршсоор байна. Охидыг ариун, нэр хүндтэй, цэвэр байлгаж, гэрлэх боломжийг нь нэмэгдүүлэх нэрийдлээр ийн хохироосоор байна.

ХҮҮХДИЙН ГЭРЛЭЛТ:

Авлах, бэлэглэх, солилцох, худалдах

Охин хүүхэд гэрлэсэнээр ихэвчлэн сургуулиасаа гарахад хүрч, хүүхэд төрүүлж, жирэмслэлтээс үүдэлтэй нас баралт, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэл нь ихэсч, ирээдүйн бүх боломж нь хаагддаг.

Хүүхдийн гэрлэлтийг бараг бүх улсад хориглосон ч дэлхий даяар өдөр бүр 33,000 хүүхдийг гэрлүүлж байна.

СУДЛААЧДЫН ТООЦООЛСОНООР ӨДГӨӨ АМЬДАРЧ БАЙГАА 650 САЯ ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮД ХҮҮХЭД НАСАНДАА ГЭРЛЭЖЭЭ.

Эцэг эхчүүд охидынхоо эдийн засгийн ирээдүйг баталгаажуулахын тулд эрт гэрлүүлсэн гэж өөрсдийгөө зөвтгөдөг. Эсвэл охидоо эдийн засгийн бараа таваар мэт үзэж, гэр бүлийн өр дарах эсвэл зөрчил шийдэх хэрэгсэл болгодог. Зарим эцэг эх охидоо эрт гэрлүүлснээр аюулгүй байдлыг нь хариуцах үүргээ нөхөр болон хадмуудад нь шилжүүлж, бэлгийн хүчирхийллээс хамгаалсан гэж үздэг. Ингэхдээ нөхөр нь бэлгийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй гэж бараг боддоггүй. Хямрал, албадан нүүлгэн шилжүүлэлтийн үед гэр бүлүүд хүүхдээ гэрлүүлэх нь ихэсдэг.

Энэ уламжлал охин хүүхдийн бие махбодыг нөхрийнх нь өмч, хэрэглээ хэмээн үзэж, онгон байдлыг нь нөхөрт нь хадгалах хүслээс үүдэлтэй.

ХҮҮГ ИЛҮҮ ЧУХАЛЧЛАХ:

Эс хүсэх, үл ойшоох, үр хөндүүлэх

Охиноос илүү хүүтэй болохыг чухалчилбал хүүтэй болохыг шаардсан дарамт шахалт ихсэж, хосууд охин төрүүлэхээс зайлсхийж (төрөхийн өмнө хүйсээр ялгаж охин хүүхдийг үр хөндүүлж) урт хугацаанд хүүхэд төрүүлэхгүй явах, эсвэл хүүдээ илүү анхаарч, охиныхоо эрүүл мэнд, сайн сайхан байдалд санаа тавихгүй (төрсний дараа хүйсээр ялгаварлах) үл ойшоодог.

Хүүг илүү чухалчилдаг уламжлал шинэ зүйл биш ч, айл өрхүүд цөөн хүүхэдтэй болж байгаа нь шинэ хандлага юм. Өнөө цагт ихэнх эмэгтэй гурав ба түүнээс цөөн хүүхэд төрүүлж байгаа нь хүүтэй болох магадлалыг бууруулж байна. Хоёр охинтой эцэг эхчүүдийн бараг дөрөвний нэг нь гурав дахь хүүхдээ охин байлгахгүйн тулд төрөхөөс нь өмнө хүйсээр ялгаж, төрүүлэх эсэхээ шийдэж байна.

ӨНӨӨГИЙН ТООЦООЛЛООС ҮЗЭХЭД ХҮҮГ ИЛҮҮ ЧУХАЛЧИЛСАНЫ УЛМААС 140 ГАРУЙ САЯ ОХИД ХОРВООД МЭНДЭЛЖ ЧАДААГҮЙ БАЙНА.

Энэ уламжлал жирэмсэн эмэгтэйчүүдийг хүчээр үр хөндүүлэхэд хүргэж, охин хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийг хаях, гадуурхах, цаашлаад охин хүүхдийг хоол, тэжээлийн дутагдалд оруулж, зохистой боловсрол олгохгүй, дархлаажуулалтад бүрэн хамруулахгүй, гадуурхахад хүргэж байна.

Зарим оронд хүүг илүү чухалчлах явдал газар авсаны улмаас нийт хүн амын хүйсийн тэнцвэр алдагдаж, эрчүүдэд эхнэр олдохгүй, жендэрт суурилсан хүчирхийлэл газар авч байна.

УЛАМ БҮР ЭСЭРГҮҮЦЭХ БОЛЛОО

Энэ хортой бурангүй уламжлалыг хүлцэн тэвчих аргагүй гэдгийг улам олон орон хүлээн зөвшөөрч байна. Олон улсын гэрээ хэлэлцээр, бусад хэрэгсэлүүдийн хүрээнд засгийн газрууд, олон нийт, хувь хүмүүсийг эдгээр уламжлалыг таслан зогсоохыг хэдэн арван жилийн турш уриалсаар ирсэн билээ.

Эдгээр уламжлалын хор уршгийг ойлгож мэддэг хүмүүсийн тоо олширч, байдал өөрчлөгдөж байна. Эм бэлэг эрхтэнг эрэмдэглэх явдал түгээмэл улс орнуудад сүүлийн хориод жилд энэхүү уламжлалыг таслан зогсоох хүсэлтэй охид, эмэгтэйчүүдийн тоо хоёр дахин өслөө. Олон улсын баримтаас үзэхэд гэрлэх эсэхээ охид өөрсдөө ул суурьтай шийдэх эрх мэдэлтэй болсоноор бага насандаа бус хожуу гэрлэж байна. Дэлхий дахинаа охидыг чадавхжуулж, жендэрийн тэгш байдал, хүний эрхийг хангахыг уриалсан нь эцэг эхчүүд охидоо сургуулиас гаргахгүй байхад нөлөөлж байна.

Гэвч энэ ахиц хангалттай биш. Хүн ам өсөхийн хэрээр хохирч байгаа охидын тоо ч өсч байна. Энэхүү бурангүй ёс уламжлалыг халах хамгийн үр дүнтэй арга бол охидын үнэ цэнийг өсгөж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах явдал боловч үүнийг хэрэгжүүлэх нь амаргүй ажил юм.

ЦААШДЫН ЗАМНАЛ

Хор уршигтай, бурангүй уламжлалыг таслан зогсоохын төлөө улс орнууд тодорхой алхмуудыг авч хэрэгжүүлэх боломжтой. Бурангүй уламжлалыг хуулиар хориглох нь нэг чухал арга хэмжээ боловч энэ нь зөвхөн эхний алхам юм. Үүнд хамгийн ихээр өртөж буй хүн амыг хамруулж энэхүү бурангүй уламжлалыг нууцаар гүйцэтгэх явдалаас урьдчилан сэргийлж болно. Мөн үндэсний түвшинд үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэхдээ олон нийт, орон нутгийн болон шашны удирдагчид, үйлчилгээ үзүүлэгчдийг нэгтгэж, дэмжлэг, оролцоог өргөжүүлж болно.

Ингэхдээ хүмүүсийн сэтгэлгээг өөрчлөхийг хичээх ёстой. Нийгмийн хэм хэмжээг өөрчлөх хөтөлбөрүүд нь хортой бурангүй уламжлалыг таслан зогсооход үр дүнтэй хэдий ч үйл ажиллагаа нь зөвхөн уламжлал дээр төвлөрч, явцуурч болохгүй. Охид, эмэгтэйчүүдийг дорд үзэх явдлыг халж, хүний эрхийг хангаж, тэдний статусыг дээшлүүлж, боломжийг нь нэмэгдүүлэх зэрэг илүү өргөн асуудлыг шийдвэрлэхэд чиглэх ёстой.

Засгийн газрууд чухал үүрэгтэй: Улс орнууд үндэсний эмэгтэйчүүдийн байгууллагуудаа чадавхжуулж, эмэгтэйчүүдийн яам, жендэрийн асуудал хариуцсан засаглалын механизмуудыг хэрэгжүүлж, охид эмэгтэйчүүдийг ялгаварласан хууль, тогтоомжуудыг цуцалж болно. Нийгмийн эрүүл мэнд, боловсрол болон бусад асуудал хариуцсан байгууллагууд мөн тодорхой үүрэг гүйцэтгэж болно.

Бодит амьдрал дээр “шидэт саваа” байдаггүй тул бид хүчин чармайлтаа эрчимжүүлж, хөрөнгө оруулалтаа өсгөж, хичээл зүтгэлээ хоёр дахин нэмэгдүүлэх хэрэгтэй. Охид бүгд сонголт хийх эрхтэй болж, бие махбоддоо эзэн нь болохоос нааш бид зогсож болохгүй.